



FONDATION POUR LES ÉTUDES
ET RECHERCHES SUR
LE DÉVELOPPEMENT INTERNATIONAL

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
Ферди олон улсын судалгааны байгууллага

СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮР АШГИЙН ТООЦОО 2017 БА 2018 ОН

ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АЛБА

Улаанбаатар 2020

Товч хураангуй

Монгол Улс 1990-ээд оноос хойш эрүүл мэндийн салбарт томоохон ололт амжилтыг гаргасан. 1998-2018 оны хооронд дундаж наслалт 65-70 нас хүртэл нэмэгджээ. Эх, хүүхдийн эрүүл мэндийн хөгжилд мөн ахиц дэвшил гарсан. 2008-2018 оны хооронд эхийн эндэгдлийн харьцаа 49-27 / 100,000 амьд төрөлт болж буурсан байна. Энэ хугацаанд нялхсын эндэгдэл 20-оос 13 / 100,000 амьд төрөлт, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 25-аас 17 / 100,000 амьд төрөлт болж буурсан.

Тэгэхээр яагаад эрүүл мэндийн байгууллагуудын үр ашиг нь Монгол улсын эрүүл мэндийн бодлогод, хамгийн түрүүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээний чухал асуудал болж байна вэ? Гэсэн асуудал гарч ирнэ.

Энэхүү судалгаа нь сумын эрүүл мэндийн төвүүдийн үр ашгийн үнэлгээ, түүнийг тодорхойлох хүчин зүйлд гол анхаарлаа хандуулсан.

Энэхүү судалгаанд бид сумын эрүүл мэндийн төв нь тодорхой хэмжээний орцыг тодорхой хэмжээний гарц болгон хувиргах хүчин чадлыг "техникийн үр ашиг" гэж нэрлэн тооцож харуулсан болно. Бидний судалгаанд техникийн үр ашгийг тооцоолсноор бага орцоор бүтээмжтэй ажиллах гарц бий болох боломжийг тусгасан болно.

Сүүлийн хорин жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарт ахиц дэвшил гарсан хэдий ч бүрэн шийдвэрлэгдээгүй асуудлууд байсаар байна. Бусад улс орны нэгэн адил манай улсад халдварт бус өвчин, түүний дотор зүрх судасны өвчин, хорт хавдар, амьсгалын замын архаг өвчин, чихрийн шижин өвчний тархалт ихсэж 2018 онд нийт нас баралтын 61 хувийг эзэлсэн байна. 2011 оноос хойш, Эрүүл мэндийн тухай хуульд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээг хөгжүүлэх ажлыг эрүүл мэндийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон албан ёсоор тусгасан. Өргөн уудам нутагт тархан суурьшсан хүн амд хот, суурин газарт өрхийн эмнэлгүүд, хөдөө орон нутагт эрүүл мэндийн төвүүд эмнэлгийн тусламжийг хүргэх гол түлхүүр болдог. Гэвч бүх хүнд хүрсэн, үнэ төлбөргүй, анхан шатны чанартай, тусламж үйлчилгээ үзүүлдэг болоход урт зам туулах шаардлагатай байна. Олон жилийн турш эрүүл мэндэд зарцуулагдсан зардлын ихэнх хувь хот суурин газрын эмнэлгүүдээс гарсан нь эрүүл мэндийн бодлогын гол зорилттой үл нийцэж, үр ашиггүй олон эх үүсвэр бий болгосон нь ажиглагдаж байна. Монгол Улс үе үе макро эдийн засгийн хүндрэлтэй тулгардаг. Эдгээр нь эдийн засгийн өвөрмөц бүтэц, дэлхийн эдийн засаг, интеграцчлалын горимтой холбоотой юм. Ковид-19 дэгдэлтийн улмаас улам бүр нэмэгдэж байгаа эдийн засгийн хямрал нь улсын төсвөөс эсвэл эрүүл мэндийн даатгалаас үл хамааран эрүүл мэндийн зардлыг нэмэгдүүлэх боломжийг эрс хязгаарлаж байна. Маш хүнд хэцүү нөхцөлд бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээг хангах, санхүүгийн хямралыг бууруулахын тулд эрүүл мэндийн байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна. Эрүүл мэндийн бодлогын гол зорилтод нийцүүлэн хамгийн сайн аргаар нөөцийг хэмнэх буюу хөдөө орон нутагт анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагын түвшинд хичнээн нөөцийг хэмнэх боломжтойг гаргах нь энэхүү судалгааны зорилго юм.

Судалгааны аргачлал

Энэхүү судалгаа нь 2017, 2018 онд шаардлагатай мэдээллийг агуулсан бүх сумын эрүүл мэндийн төвүүдийг хамарсан (нийтлэг жишгээс гадуурх санхүүжилт болон жишигээс гадуурх үр дүн гарсан СЭМТ-г хассаны дараа 2017 онд 233, 2018 онд 261 байгууллагыг хамруулсан). Техникийн үр ашгийг СЭМТ бүрийн хувьд ялгаварлалгүйгээр үр ашгийн оноог гаргахын тулд параметрийн бус /түүвэр дотрох хамгийн сайныг бусадтай нь жишиж судлах/, Мэдээллийн боловсруулалтын дүн шинжилгээний давхар ачааллах

аргыг /үр ашгийн судалгаанд хамгийн их ашиглагддаг/ ашиглан тооцоолсон. Эдгээр оноо нь харьцангуй оноо, тухайлбал, хамгийн дээд оноо нь 1 бөгөөд хамгийн бага нөөц ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн СЭМТ-д өгсөн оноо. Бусад СЭМТ-уудын үр ашгийг хамгийн сайн гүйцэтгэлтэй СЭМТ-ийн үр ашигтай хамааруулж үнэлдэг бөгөөд энэ нь жишиг үзүүлэлт болсон. СЭМТ-үүдийн орц (ашигласан нөөц) ба гарц (эрүүл мэндийн тусламж үйлчилгээ) -ийн аль алиныг нь ашиглан ижил төстэй үр дүн гаргаж буй бусад загваруудыг ашиглан техникийн үр ашгийг долоон загвараар үнэлэв. Гол загварт бид орцыг эмч, эмнэлгийн бусад ажилтнуудын тоо, орны тоогоор; гарцыг урьдчилан сэргийлэх үзлэг, давтан үзлэг, хэвтэн эмчлүүлэгчдийн тоогоор ашиглаж тооцоолсон. Эконометрик дүн шинжилгээг СЭМТ-ийн үр ашигт нөлөөлж чадахуйц бусад хүчин зүйлсийн нөлөөг тооцоолоход ашигласан. Сумын хэмжээнд хүн амын тоо, нягтрал, хамаарлын түвшин, ядуурлын түвшин, малчин өрхийн хүн ам дахь эзлэх хувийг харгалзан үзсэн. СЭМТ-ийн түвшинд эрүүл мэндийн нийт ажилтнуудын дунд эмч нарын эзлэх хувийг СЭМТ-ийн үр ашгийг тодорхойлох хүчин зүйл гэж үзсэн. Арга аргачлал ба хувьсах аргачлалын талаар тайлангийн 4-р хэсэгт нарийвчлан тусгасан болно.

Үр дүн ба үндсэн ач холбогдол /Эрүүл мэндийн бодлогод/

Үр дүнгээс харахад СЭМТ-үүдийн дундаж үр ашиг 2017, 2018 онуудад 0.72 оноотой ажиллаж байна. Энэ нь дунджаар СЭМТ-үүд ижил түвшний үйл ажиллагаа явуулж буй бөгөөд ашиглаж буй нөөцийн 30 орчим хувьтай тэнцэх хэмжээний хэмнэлт гаргах боломжтой гэсэн үг юм. Нөхцөл байдал нэг СЭМТ-ээс нөгөөд эрс ялгаатай бөгөөд хамгийн бага оноо 0.4 байна. СЭМТ-үүдийн тавны нэг нь 0.6-аас доош үр ашгийн оноотой бол бараг 10% нь 0.4-ээс 0.5 хооронд оноо авсан байна (дугуй дүрс). Иймээс СЭМТ-ийн үр ашгийг мэдэгдэхүйц сайжруулвал их хэмжээний нөөцийг хэмнэж, хөдөө орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах бодлогыг эрс нэмэгдүүлж байгаа юм.

Түүнээс гадна, регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад ядуурал ихтэй суманд байрладаг СЭМТ нь бусад СЭМТ-тэй харьцуулахад үр ашиг багатай байна. Энэ нь бүх хүнд анхан шатны тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авах зарчимтай хэдий ч ядуурал нь хөдөө орон нутаг дахь эрүүл мэндийн хүртээмж, тэгш байдлыг хангахад саад болж байгааг харуулж байна. Малчин өрхийн хүн ам ихтэй сумдад байрладаг СЭМТ-ийн хувьд харьцангуй үр ашигтай ажиглагдаж байна. Эсрэгээрээ хамаарлын түвшин, хүн амын нягтрал ихтэй сумдад байрладаг СЭМТ нь бусадтай харьцуулахад илүү үр дүнтэй байх хандлагатай байна. Судалгаанаас гарсан бас нэг сонирхолтой үр дүн бол суман дахь эрүүл мэндийн ажилтнууд болон сумын хүн амын тооны хамаарал нь СЭМТ-ийн үр ашигт нөлөөж байна уу гэсэн асуудлыг гаргаж ирсэн. Ажилтнуудын ажлын бүтээмжийн талаар хийсэн тооцоололд, батлагдсан тодорхой хамаарал байгаагүй.

Судалгааны үр дүн нь эрүүл мэндийн бодлогын түвшинд хэд хэдэн нөлөө үзүүлж чадахуйц байна. Бидний үр дүнд дараахь зүйлс нь чухал болохыг харуулсан.

1. Нөөцийг чөлөөлж, орон нутагт эрүүл мэндийн санхүүжилтийн хязгаарлалтыг сулруулах замаар үр ашгийг эрс сайжруулах боломжтой,
2. Эмнэлгийн ажилтнуудын үр ашгийг дээшлүүлэх, СЭМТ-үүдийн дунд газарзүйн хуваарилалтыг илүү үр дүнтэй болгохыг хичээх
3. Үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд нөөцийнхөө тодорхой хэсгийг ашиглан СЭМТ-ийн эмч нарын байр суурийг илүү сонирхол татахуйц болгох /төсвөөс СЭМТ-д очиж ажиллах сэдэл төрүүлэх арга хэмжээ авах/
4. СЭМТ-ийн үр ашигт нөлөөлж буй ядуурлын сөрөг үр нөлөөг бууруулах,

А. үр ашиг багатай, ядуурлын түвшин өндөр сумдад нийгмийн даатгалын нөхцөлт, зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж СЭМТ-ийн үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах

Б. нэн ядуу өрхүүдэд тулгардаг ялангуяа хувиасаа төлөх төлбөрийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах

5. Үр ашиг багатай СЭМТ, өндөр үр ашигтай СЭМТ-ийн ялгааг нарийвчлан тодорхойлохын тулд гүнзгийрүүлсэн судалгааг хийх. Энэ нь маш чухал асуудал бөгөөд өгөгдөл дутуугаас гадна зарим асуудал, шалтгааныг тодорхойлохын тулд дан ганц тоон судалгаа хангалтгүй юм.

Эцэст нь энэхүү судалгаа нь гурван ерөнхий асуудлыг онцлон тэмдэглэсэн.

Нэгдүгээрт, хүмүүсийн дийлэнхийн бодлоор үр ашгийг дээшлүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хоёрын хооронд хамаарал бий гэж боддог гэтэл шууд хамааралтай, шууд хамааралгүй аль ч биш байна. Хоёрдугаарт, үр ашгийг дээшлүүлэхэд хүчин чармайлт шаарддаг бөгөөд эхний үед тухайн байгууллагад хүндрэл бий болгодог. Энэ нь орцоо багасгаж гарцаа үр ашигтайгаар буюу хэвээр авч үлдэх шаардлагатай тул туршлагаас харахад СЭМТ-үүдийн ажилтнууд энэ тал дээр шүүмжлэлтэй хандана. Тиймээс ажилтнуудын авдаг нэмэлт урамшууллын багц (улирлын урамшуулал гэх мэт) -г эргэн харах, шаардлагатай бол тэдгээрийг үр ашгийг дээшлүүлэх зорилт болгон Эрүүл мэндийн яамнаас нэмэлтээр тусган зохицуулах шаардлагатай болно. Гуравдугаарт, энэхүү судалгаа нь үр ашгийг дээшлүүлэх нь байгаа нөөцийг хэмнэх эсвэл гарах үр дүнг сайжруулах боломжтойг нотолж байна. Учир нь 2018 онд СЭМТ-үүд засгийн газраас эрүүл мэндэд зарцуулсан нийт зардлын 19 хувийг эзлэж, эрүүл мэндийн салбарын нийт ажиллах хүчний 12 хувийг ажиллуулж байжээ. Үр ашгийг дээшлүүлэх нь эрүүл мэндийн төсөв хэмнэх, даатгалын орон зайг өргөжүүлэх хүчирхэг арга бөгөөд энэ нь Монгол Улсад, ялангуяа эрүүл мэндийн анхан шатны тусламжийг үзүүлэхэд, хурдан ахиц гаргахад чухал ач холбогдолтой юм.

1. Үндэслэл

Энэхүү судалгаа нь сумын эрүүл мэндийн төвүүдийн үр ашгийн үнэлгээ, түүнийг тодорхойлох хүчин зүйлд гол анхаарлаа хандуулсан.

Энэхүү судалгаанд бид сумын эрүүл мэндийн төв нь тодорхой хэмжээний орцыг тодорхой хэмжээний гарц болгон хувиргах хүчин чадлыг "техникийн үр ашиг" гэж нэрлэн тооцож харуулсан болно. Бидний судалгаанд техникийн үр ашгийг тооцоолсноор бага орцоор бүтээмжтэй ажиллах гарц бий болох боломжийг тусгасан болно.

Монгол Улс 1990-ээд оноос хойш эрүүл мэндийн салбарт томоохон ололт амжилтыг гаргасан. 1998-2018 оны хооронд төрөлтийн дундаж наслалт 65-70 нас хүртэл нэмэгджээ. Эх, хүүхдийн эрүүл мэндийн хөгжилд мөн ахиц дэвшил гарсан. 2008-2018 оны хооронд эхийн эндэгдлийн харьцаа 49-27 / 100,000 амьд төрөлт болж буурсан байна. Энэ хугацаанд нялхсын эндэгдэл 20-оос 13 / 100,000 амьд төрөлт, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 25-аас 17 / 100,000 амьд төрөлт болж буурсан.

Яагаад энэхүү судалгааг хийх хэрэгтэй вэ? Гэсэн асуудал гарч ирнэ. Сүүлийн хорин жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарт ахиц дэвшил гарсан хэдий ч бүрэн шийдвэрлэгдээгүй асуудлууд байсаар байна. Бусад улс орны нэгэн адил манай улсад халдварт бус өвчин, түүний дотор зүрх судасны өвчин, хорт хавдар, амьсгалын замын архаг өвчин, чихрийн шижин өвчний тархалт ихсэж 2018 онд нийт нас баралтын 61 хувийг эзэлсэн байна. 2011 оноос хойш, Эрүүл мэндийн тухай хуульд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээг хөгжүүлэх ажлыг эрүүл мэндийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон албан ёсоор тусгасан. Өргөн

уудам нутагт тархан суурьшсан хүн амд хот, суурин газарт өрхийн эмнэлгүүд, хөдөө орон нутагт эрүүл мэндийн төвүүд эмнэлгийн тусламжийг хүргэх гол түлхүүр болдог. Гэвч бүх хүнд хүрсэн, үнэ төлбөргүй, анхан шатны чанартай, тусламж үйлчилгээ үзүүлдэг болоход урт зам туулах шаардлагатай байна.

Монгол Улс үе үе макро эдийн засгийн хүндрэлтэй тулгардаг нь эдийн засгийн өвөрмөц бүтэц, дэлхийн эдийн засгийн нөлөө, интеграцчлалын горимтой холбоотой юм. Ковид-19 дэгдэлтийн улмаас улам бүр нэмэгдэж байгаа эдийн засгийн хямрал нь улсын төсвөөс эсвэл эрүүл мэндийн даатгалаас үл хамааран эрүүл мэндийн зардлыг нэмэгдүүлэх боломжийг эрс хязгаарлаж байна. Маш хүнд хэцүү нөхцөлд бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээг хангах, санхүүгийн хямралыг бууруулахын тулд эрүүл мэндийн байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн бодлогын гол зорилтод нийцүүлэн хамгийн сайн аргаар нөөцийг хэмнэх буюу хөдөө орон нутагт анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагын түвшинд хичнээн нөөцийг хэмнэх боломжтойг гаргах нь энэхүү судалгааны зорилго юм.

Судалгаа дараах бүтэцтэй буюу 2-р хэсэгт яагаад СЭМТ-ийн үр ашгийг дээшлүүлэх нь Монгол Улсын эрүүл мэндийн бодлогын, ялангуяа эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авдаг, бүх нийтэд хүртээмжтэй үзүүлэхэд чухал асуудал болж байгааг харуулав. 3-р хэсэгт Монгол Улсын эрүүл мэндийн систем дэх СЭМТ-ийн үүрэг, засаглал, санхүүжилтийн талаар хийсэн дүн шинжилгээг тусгасан. 4-р хэсэгт үр ашгийн оноог тооцоолоход ашигладаг аргуудыг танилцуулж, үр ашигт нөлөөлөх хүчин зүйлийн багцыг онцолсон болно. 5 болон 6-р хэсэгт үр ашгийн оноог тооцоолсон үр дүн болон судалгаанд авч үзсэн боломжит тодорхойлогчдын үүргийг тусгасан. 7-р хэсэгт үндсэн үр дүнг нэгтгэн, зарим асуудлыг илүү нарийвчлан, бодлогын хэрэгжилтэнд нөлөөлж чадахуйц дүгнэлт, зөвлөмж гаргасан.

2. Яагаад эрүүл мэндийн байгууллагуудын үр ашиг нь Монгол улсын эрүүл мэндийн бодлогод, хамгийн түрүүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээний чухал асуудал болж байна вэ?

Монгол Улс сүүлийн хорин жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарт томоохон ахиц дэвшилд хүрсэн байна. Гэсэн хэдий ч эдгээр эерэг ололт амжилтуудаас гадна манай улс эрүүл мэндийн салбарт болон макро эдийн засгийн салбарт эрүүл мэндийн бодлогын санхүүжилт, бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээг хэрэгжүүлэх чухал сорилтуудтай тулгарч байна. Тиймээс үр ашгийг дээшлүүлэх нь эрүүл мэндийн бодлогын тэргүүлэх зорилт, зайлшгүй шаардлага болоод байна.

2.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах зайлшгүй хэрэгцээ нь бүрэн хангагдахгүй байна

Хэдэн жилийн турш эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэд үнэ төлбөргүй авах нь Монгол Улсын эрүүл мэндийн бодлогын зорилтын төвд байсаар ирсэн. Гэсэн хэдий ч, бусад олон төрлийн судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг цогцоор үзүүлэхэд ихээхэн хүчин чармайлт шаардагддаг (Жигжидсүрэн нар 2019) гэж тодорхойлжээ. Монгол Улсад халдварт бус өвчний тархалт хурдтайгаар нэмэгдэж байна. Одоогоос 30 жилийн өмнө Монголд бараг байхгүй байсан чихрийн шижин өвчний өвчлөл одоо 6 дахин нэмэгдэж, долоон хүний нэг нь тус өвчнөөр оношлогдож, нас баралтын тоо огцом нэмэгдэж байна. Тоймловол зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин 2018 онд нас баралтын 61

хувийг эзэлсэн байна (ЭМХТ, 2018). Халдварт бус өвчин (ХБӨ) нь эрүүл мэндийн тогтолцоогоор зогсохгүй улсын эдийн засагт өндөр өртөг үзүүлдэг бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, айл өрхөд үзүүлэх дарамтыг улам бүр нэмэгдүүлж байна. ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн санхүүжилт бага, тусламж үйлчилгээний шатлалын хуваагдал, анхан шатны тусламж үйлчилгээний хязгаарлагдмал хуваарилалт зэрэг асуудлууд нь ХБӨ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тохиолдлыг илрүүлэх, эрт эмчлэх чиг үүргийн уялдаа холбоог алдагдуулж байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хуваарилалт жигд бус, олон улсын жишигт үл нийцсэн бүтэцтэй, чанартай тусламж үйлчилгээ авч чадахгүй байгаа нь өвчтөнүүдийг анхан шатны байгууллагыг алгасан, илүү үнэтэй хоёрдогч болон гуравдагч шатны үйлчилгээнд хамрагдахад хүргэдэг бөгөөд ингэснээр эрүүл мэндийн тогтолцооны хувьд үр ашиггүй байдал бий болдог.

Хэдий ахиц дэвшил гарч үр дүнд хүрсэн боловч хүн амын зарим хэсэгт төрөлжсөн мэргэжлийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэхэд газарзүйн болон санхүүгийн хувьд томоохон саад бэрхшээл байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тусламж үйлчилгээний хүртээмжийн санхүүгийн хүндрэл нь эрүүл мэндийн тогтолцоо, түүний санхүүжилт, ядуурлын асуудал зэргээс шалтгаалж байна. Ядуурлын түвшин 2010 оны 38.8% -иас 2018 онд 28.4% болж буурсан (ҮСХ, 2020), ядуурлын түвшин сарын дундаж хэрэглээ 7.2% -иас бага байсан (ядуурлын ялгаа). Бүс нутгийн тэгш бус байдал нэлээд их байна (Зүүн бүсэд 37.4%, Баруун бүсэд 31.8%, Хангайн бүсэд 30.8%). Үүнээс гадна нийт хүн амын 15% нь ядуурлын түвшнээс 1.25 дахин их байгаа нь тэднийг янз бүрийн хэлбэрийн цочролд өртөмтгий болгодог. Халааснаас гарах шууд төлбөр нь 1995-2012 оны хооронд эрүүл мэндийн нийт зардлын 12% -иас 42% -иар өссөн байна. Халааснаас гарах шууд төлбөр нь ядуу өрхүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг хязгаарлаж, ядуурлын түвшинг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг (Дүгрээ нар 2019 он.). Халааснаас гарах шууд төлбөр нь дундаж орлоготой орнуудын дунджаас (39%) өндөр байна. Олон улсын туршлагаас харахад халааснаас гарах төлбөрийн харьцангуй өндөр түвшин нь бүх нийтийн эрүүл мэндийн хамрах хүрээг нэмэгдүүлэхэд саад болдог байна. Эрүүл мэндийн төсвийн хамгийн их хувийг цалингийн тооцоо, барилга байгууламжид зарцуулдаг бөгөөд энэ нь урсгал засварын санхүүжилтийг дутуу зарцуулж, урт хугацаанд өндөр өртөгтэй болоход хүргэдэг (Дэлхийн банк 2018).

Энэ бүхэн нь Монгол Улсын эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нэмэлт санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байгаа гэсэн үг юм. Монгол Улс эрүүл мэндийн даатгал, засгийн газрын төсвөөр санхүүждэг хэдий ч эрүүл мэндийн санхүүжилтэд ноцтой бэрхшээл тулгарч байна.

2.2 Даатгал, төсвөөр дамжуулан эрүүл мэндийн тусламжийг санхүүжүүлэхэд тулгардаг томоохон санхүүгийн бэрхшээлүүд

2.2.1 Албан бус салбарын даатгалын үйл ажиллагааг өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд

Засгийн газар даатгалын салбарыг бэхжүүлж, хөгжүүлэхээр ажиллаж байгаа боловч эрүүл мэндийн даатгалын ихэнх эх үүсвэр нь албан ёсны салбараас бүрддэг бөгөөд энэ нь хүн амын 50 хүрэхгүй хувийг эзэлдэг. Албан бус салбарын даатгалын шимтгэлийг сайжруулах нь эмзэг асуудал юм, ялангуяа ядуурал 2010-2014 оны хооронд 39% -иас 22% хүртэл буурч байсан бол 2016 онд огцом 30% болж өсч

одоогийн 28% орчимд тогтворжсон мэт харагдаж байна. Төсөв арилжаалахтай холбоотой төсвийн даатгалын шимтгэл буюу татаас бага байдаг хэдий ч хамгийн түрүүнд засгийн газрын төсөвт учирч буй бэрхшээлээс үүдэлтэй гэж үзэж байна.

2.2.2 Эдийн засаг бүтцийн хувьд хэврэг байгаа тул төсвийн хүнд хэцүү байдал үүссэн

Төсвийн хүндрэлүүд (Ковид-19 тахал өвчний улмаас улам дордсоор байна) нь Ковид-19-ийн улмаас үүссэн нөхцөл байдалд богино хугацаанд санхүүгийн хариу арга хэмжээ авахаас үл хамааран богино болон дунд хугацаанд нийгмийн эрүүл мэндийн зардлыг мэдэгдэхүйц ихэсгэж байна. Энэ нь эрүүл мэндийн тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх ач холбогдлыг улам бататгаж байгаа юм. Доорх 4 асуудал нь бүтэц, зохион байгуулалтын болон урт хугацаанд шийдэгдэх шинж чанартай учир Ковид-19 тахлын төгсгөлд ч арилахгүй юм.

А. Монгол Улс 2016 оны эдийн засгийн уналтаас хойш сэргэж байгаа боловч эдийн засгийн эмзэг суурь нь гадаад орчноосоо ихээхэн хамааралтай. Тухайлбал, экспортын 80 хувь нь уул уурхай, Монголын экспортын 90 хувийг Хятад улсруу гаргадаг бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын тал хувь нь Оюу Толгойн уурхай (ОУВС, 2017) гэсэн ганц төсөлд төвлөрсөн байдаг. Гэсэн хэдий ч Монгол Улсын 2017-2018 оны өсөлтөд гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал үүрэг гүйцэтгэсэн нь мэдэгдэж байна.

Б. Ковид-19-ээс үүссэн хүндрэл бэрхшээлээс үл хамааран богино хугацаанд бий болсон эдийн засгийн уналт нь дэлхийн эдийн засгийн уналтаас мөн хамааралтай. Доорх гурван эрсдлээс шалтгаална: а) Ашигт малтмалын эрэлт (тоо хэмжээ, үнэ)-д цочирдох эрсдэл; (б) Ковид-19-ээс өмнөх Монгол улсын одоогийн бодлогын дагуу төсвийн урсгал алдагдлыг санхүүжүүлэхэд гадаад санхүүжилтийг их хэмжээгээр шаардахад хүргэдэг; (в) Олон өр, зээлтэй иргэд, өрх, хэд хэдэн банкуудын хөрөнгийн алдагдал зэрэг санхүүгийн дотоод эрсдэл. Олон улсын валютын сан (ОУВС, 2019)-аас гаргасан мэдээгээр засгийн газраас гаргасан өрийн хэмжээ ДНБ-ий 95% -д хүрч, валютын нөөц нь импортын 2 долоо хоногтой дүйцэхүйц байгаа нь одоогийн жишгээр маш бага байна.

В. Ковид-19-ээс өмнөх 10 жилийн хугацаанд манай улс өр, санхүүжилтийн талаар тогтворгүй байдалтай тулгарч гурван том цочролыг даван туулж байсныг санаж байх хэрэгтэй: 2008-09 оны дэлхийн санхүүгийн хямрал; 2010 онд байгалийн гамшиг - зуд ; дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн огцом уналт 2013-14; 2016 оны дотоодын хямрал. Одоо, Ковид-19-ийн нөлөөнөөс үүдэлтэй уналт явагдаж байна. Ковид-19 тахал гарахаас өмнө засгийн газар 2020-2024 онуудад ДНБ-ний 1 хувиас доошгүй орлогыг (ДНБ-ийг 2021 онд -0,5% болгоно гэж тооцоолсон ч үр дүнд хүрээгүй байгаа) өрийг бууруулах тэргүүлэх чиглэл болгоно гэж зорилт тавьсан. Эдийн засгийн нөхцөл байдал хүлээгдэж байснаас илүү тааламжтай болж эхэлвэл улсын төсвийн аливаа нэмэлт орлогыг өр төлбөрийг хурдан төлж барагдуулахад хэрэглэх болно.

Г. Эцэст нь хэлэхэд эрүүл мэндийн асуудал нь хязгаарлагдмал төсвийн эх үүсвэрээс ашиг хүртэхийн тулд бусад асуудлуудтай өрсөлдөж байгааг санах нь зүйтэй. Хоёрхон жишээ дурьдахад: Хүүхдийн мөнгө хөтөлбөр, мал аж ахуйн салбарын зардал. Нийгмийн гол хөтөлбөр болох хүүхдийн мөнгө хөтөлбөр бол болзолгүй мөнгө шилжүүлэх хөтөлбөр юм. Энэ нь үр дүнтэй гэж тооцогддог боловч эмзэг бүлгийн өрхүүдэд илүү их нөлөө үзүүлэхийн тулд илүү их

санхүүжилт шаарддаг. Мал аж ахуйн салбарын тухайд Монгол Улс энэ салбарт нөлөөлж буй хүчин зүйлстэй тэмцэх шаардлагатай байна. Их хэмжээний бэлчээрийн талхлагдал (нийт өвсний 65%), эрс тэс уур амьсгалын үзэгдлүүдийн улмаас мал аж ахуйн салбарт санхүүжилт ихээр шаардагдах болсон. Энэ нь хөдөөгөөс Улаанбаатарт шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлж гэр хорооллыг улам өргөтгөн, хотын ядуу иргэдийн тоог нэмэгдүүлж үндсэн үйлчилгээ үзүүлэх засгийн газрын чадавхийг давсан хэрэгцээ болоод буй юм.

2.2.3 Тулгамдаж буй асуудлууд Ковид-19-ээр улам бэхжив

Бидний дээр онцолсон асуудлууд нь Ковид-19 дэгдэлтээс өмнөх үеийн Монголын

Хүснэгт 1. Монголын эдийн засагт Covid-19-ийн үзүүлж буй нөлөө

2020 1-р улирал 2019 1-р улиралтай харьцуулагдсан дүн
(өөрчлөлтийн% өөрөөр заагаагүй болно)

ДНБ (2010 оны тогтмол үнэ)	-11
Аж үйлдвэрийн нийт гарц	-24
Уул уурхай, олборлох	-33
Засгийн газрын нийт төвлөрсөн орлого ба тусламж	-22
Засгийн газрын нийт төвлөрсөн зарлага ба цэвэр зээлийн хэмжээ	15
Төсвийн тэнцэл: ДНБ-ий 8% -иас илүүдэлтэй, 20% -ийн алдагдалтай	
Бараа бүтээгдэхүүний экспорт	-45
Бараа бүтээгдэхүүний импорт	-10
Гадаад худалдааны тэнцэл: ДНБ-ий 21% -иас илүүдэлтэй, 7% -ийн алдагдалтай	

Source: From National Statistics Office, Statistical Bulletin, Avril 2020

эдийн засагт ноцтой нөлөөлж байсан асуудлууд байв. Засгийн газар үүнийг шийдвэрлэхийн тулд хэд хэдэн арга хэмжээ авсан. Монгол Улсын эдийн засагт 2020 оны эхний дөрвөн сарын үзүүлэлтүүдийг 2019 оны мөн үетэй харьцуулсан дүнг Хүснэгт 1-д харуулав. ДНБ 11%, аж үйлдвэрийн үйлдвэрлэл 24% -иар буурч, засгийн газрын төвлөрсөн орлого огцом буурсан (-22%). Үүний зэрэгцээ, Ковид-19-ийн үр нөлөөтэй тэмцэхэд зарцуулсан зардлын өсөлт (15%) нь төсвийн

тэнцлийг ДНБ-ий 8% -иас давсан алдагдал 20% -ийн алдагдалд хүргэсэн байна. Гадаад данс мөн муудсан нь экспорт ялангуяа Хятад руу гаргах экспорт буурсантай холбоотой байв. Үүний үр дүнд худалдааны тэнцэл тухайн үеийн ДНБ-ий 21% -аас илүүдэлтэй, 7% -ийн алдагдалтай гарч, хөрөнгийн данс, валютын нөөцөд ихээхэн дарамт учруулсан. Тиймээс Ковид-19-ээс өмнө байсан эрэлт хэрэгцээг хангахын тулд эрүүл мэндэд зарцуулах зардлыг нэмэгдүүлэхэд илүү төвөгтэй. Орлогын шок, төсвийн шок, төлбөрийн тэнцлийн шок гэсэн 3 нөлөөг хамтад нь шийдэх хэрэгтэй болно.

Дүгнэж хэлэхэд Ковид-19-ээс өмнө сүүлийн хорин жилийн туршид Монголын эдийн засагт ахиц дэвшил гарсан хэдий ч эрүүл мэндийн салбарт дорвитой нөлөө үзүүлж чадаагүй. Хангагдаагүй хэрэгцээ нь хэвээр байгаа бөгөөд үүнийг санхүүжүүлэхийн тулд макро эдийн засгийн хүндрэлүүдийг арилгах шаардлагатай байна. Ковид-19 тахал өвчний улмаас улсын эдийн засаг маш хүндэрч байгаа бөгөөд үйл ажиллагааны алдагдал нь хүлээгдэж буй сэргэлтээс үл хамааран нэлээд урт хугацаанд хэвээр байх болно. Засгийн газар 2020 оны 5-р сарын 6-ны өдөр төсвийн арга хэмжээг зардлын бууралтаар бүрэн нөхөх бодолтой байгаа гэсэн мэдэгдлийг энд тэмдэглэж бичих нь зүйтэй. Саяхан Засгийн газар ОУВС-тай 99 сая долларын өртөг бүхий яаралтай санхүүжүүлэх тухай гэрээ хэлэлцээрийг хийж дуусгасан. ОУВС-аас иш татан дурдсанаар, "цар тахал буурсны дараа, тэргүүлэх чиглэл нь улсын өрийг бууруулах, валютын нөөцийг бий болгох замаар уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд шилжих ёстой" гэж тохиролцсон байна.

Бодит нөөцийг нэмэгдүүлэхтэй ижил төстэй эрүүл мэндийн байгууллагуудын үр ашгийг сайжруулах нь Монгол Улсын эрүүл мэндийн бодлогын нэн тэргүүний зорилт болж байна.

3. Монгол улсын эрүүл мэндийн тогтолцоо-сүүлийн 20 жилийн тойм

Монгол улсын эрүүл мэндийн тогтолцоо захиргааны бүтцийн дагуу аймаг, нийслэл, сум (дүүрэг), баг (тосгон)- гэсэн зохион байгуулалттай. Монгол Улс 21 аймагтай, аймаг бүр 15-27 сумтай, сум бүр 4–8 багтай. Энэ нь баг, сумын түвшинд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд ба аймаг, нийслэлийн түвшинд хоёрдогч, гуравдагч шатлалын төрөлжсөн үйлчилгээ үзүүлж байгаа хоёр давхрага бүхий тогтолцоо

70 жилийн турш социалист тогтолцоогоор явж ирсэн Монгол улс 1990-ээд оны эхээр зах зээлийн эдийн засагт шилжиж, эрүүл мэндээс авахуулаад бүх салбарт шинэчлэл хийж эхэлсэн. Тэр үеэс хойш эрүүл мэндийн тогтолцоо аажмаар төвлөрсөн “Семашко” загвараас төвлөрлийг арай бууруулсан санхүүжилт болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоонд шилжин хувийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн оролцоо болон иргэдийн хувиасаа хийх төлбөрийн үүрэг нэмэгдсэн. Социализмын үед хүрсэн бүх нийтийн хамралтыг төрийн санхүүжилт эрс буурахад хадгалж үлдэхийн сацуу үр ашиг, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хөшүүрэг нэвтрүүлэх нь тогтолцоонд тулгарч байгаа гол асуудал болоод байна.

Эрүүл мэндийн зардлын ихэнхи хувийг улсын төсвөөс санхүүжүүлдэг байсан ба нийт хүн амын эрүүл мэндийн хамгаалахад зориулагддаг. Гэсэн хэдий ч бодит байдал дээр эрүүл мэндийн зардлын ихэнхи хувийг нийгмийн эрүүл мэндийн бодлого, стратеги гэхээсээ өндөр үнэтэй, үр ашиг багатай эмнэлгийн үйлчилгээнд зарцуулагддаг. Эдийн засгийн шилжилттэй холбоотойгоор, улсын төсвөөс нийгмийн салбарыг санхүүжүүлэх үйл явц нуран унаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар муудан, эрүүл мэндийн тогтолцоо үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон. Эдийн засгийн шилжилтийн үед нийгмийн салбарыг санхүүжүүлэх улсын зардал буурч, эрүүл мэндийн тогтолцоо өөрөө өөрийгөө барьж чадахгүй байсан тул эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар эрс буурсан. Энэхүү шилжилтийн үеэр олон улсын тусламж, хандивын байгууллагууд Монгол улсад тусалцаа үзүүлэн, Зөвлөлтийн нийгмийн болон санхүүгийн зардлыг нөхөхөд тусалсан юм. 1990-ээд оны эхээр эрүүл мэндийн салбарын төсөвт орж ирсэн нөөцийн зөрүүг хэрэглэгчдийн төлбөрийг тогтмол нэвтрүүлэх замаар, 1994 онд эрүүл мэндийн даатгалыг зайлшгүй байдлаар нэвтрүүлснээр нөхсөн.

Монгол улсын эрүүл мэндийн тогтолцоо нь эрүүл мэндийн даатгал болон улсын төсөв гэсэн санхүүжилтийн эх үүсвэртэй. 2010 онд, эрүүл мэндийн даатгалаас нийт эрүүл мэндийн зардлын 23,6%-ийг санхүүжүүлэн, нийт хүн амын 82.6% -ийг хамруулсан. Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр голчлон эмчилгээний үйлчилгээг хоёр болон гурав дахь шатлалын эмнэлгүүдээр дамжуулан хүргэдэг боловч тэдгээр нь амбулаторийн хязгаарлагдмал үйлчилгээг үзүүлдэг. (Чимэддагва, 2011). 1993 оноос хойш эрүүл мэндийн тусламж үйлчилгээний "зайлшгүй" болон "нэмэлт" багцыг бий болгох олон оролдлого хийжээ. “Зайлшгүй” багц нь эрүүл мэндийн даатгал хамрагдсан эсэхээс үл хамааран үнэ төлбөргүй үзүүлдэг. Үүнд эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ; сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн өвчин болон удаан хугацааны эмчилгээ шаарддаг бусад өвчнүүд, халдварт өвчний дэгдэлт, халдваргүйжүүлэлтийн

менежмент, жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ, мөн 2006 оноос эхлэс эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ багтдаг болжээ.

Бусад бүх эмчлэх болон оношилгооны үйлчилгээ нь “нэмэлт” багцад багтдаг бөгөөд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг болно. 2003 онд гаралтад суурилсан төсөвлөлтийг баталснаас өөрөөр эрүүл мэндийн салбар уламжлалт Семашко загвараар төсвийн зардлын эдийн засгийн ангилалалаар санхүүжиж байгаа. Эмнэлгийн дарга нар цалин, хөрөнгө оруулалт хийх зэргээр нөөцийн дахин хуваарилалтыг зөвшөөрдөггүй бол бусад дээд шатны байгууллагуудын зөвшөөрлөөр үүнийг хийх боломжтой байдаг. Эмнэлгийн дарга нар төсвийг хэмнэх, аль эсвэл төсөвт зардлыг хэтрүүлэх боломжгүй байдаг. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн олон шинэчлэлүүлд хийгдэж байгаа ч төрийн зохицуулалтын хүнд суртал бүхий “тушаал, удирдлага”-аас жолоодлогыг гартаа авах шаардлагатай байна.

Төсвийн тухай хууль (ТТХ) эрүүл мэндийн салбарт үйлчилгээ үзүүлэгчдийг санхүүжүүлэхэд олон өөрчлөлт оруулсан. Ялангуяа анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх дүрэм журамд өөрчлөлт орсон байна. ТТХ нь орон нутагт шийдвэр гаргах шинэ эрх мэдлийг олгосон билээ. Энэ нь аймаг, нийслэл, сумын түвшинд төсөв боловсруулах, төлөвлөхөд шийдвэр гаргах эрх мэдлийг нэмэгдүүлсний зэрэгцээ байгууллагын захирал нарт хүний нөөцийн үйл ажиллагаа, тэр дотроо хүн ажилд авах, халах, урамшуулал олгоход нэлээд эрх мэдэлтэй оролцох боломжийг бүрдүүлжээ.

2002 оноос эхлэн хот суурин газрын анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ өрхийн эрүүл мэндийн тогтолцоонд бүрэн шилжүүлж, 2008 он гэхэд нийт хүн амын талаас илүү хувь нь Улаанбаатар хотын бүх дүүрэгт болон аймгийн төвүүдэд байгуулагдсан 228 өрхийн эмнэлэгт хамрагдсан байна. Өрхийн эмнэлгүүд байгуулагдсан нь сайн бодлого гэж ойлгогдож байсан бөгөөд энэ нь засгийн газрын анхаарлыг анхан шатны тусламж үйлчилгээн дээр суурилсан хандлагад амжилттай шилжүүлж чадсан юм.

Засгийн газар 1997 онд эрүүл мэндийн салбарын хувьчлалын тухай тогтоол гаргаж, нийгмийн салбарыг хувьчлах удирдамжийг 2001 онд Улсын Их Хурал баталжээ. 2003 он гэхэд Монгол Улсад 840 гаруй эрүүл мэндийн байгууллагууд, ихэнхдээ хувийн эмийн сангууд бүртгэлтэй байсан ба энэ тоо 3069 эмнэлгийн ортой 1184 хувийн эмнэлэг, 519 хувийн эмийн сан болтлоо өсчээ. (ЭМЯ 2011). 2011 онд төр, хувийн хэвшлийн түншлэлийн стратеги батлагдсан. Түүнчлэн, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт хувийн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчдэд мэдэгдэхүйц нэмэгдсэн. Хэдий тийм ч зохицуулалтын орчныг улам боловсронгуй болгосноор хувийн хэвшлийн байгууллагууд хүн амд тэгш, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлж үүргийг нь илүү ач холбогдолтой болно.

3.1 Сумын эрүүл мэндийн төвийн үүрэг, засаглал, санхүүжилт

1990 онд социалист төрийн тогтолцоо нуран унасны дараа Монгол Улс неолиберал эдийн засагтай ардчилсан тогтолцоонд шилжихийн тулд улс төр, эдийн засгийн шинэчлэлийг хийжээ. Социалист дэглэмийн үед байгуулагдсан Семашко маягийн төвлөрсөн, шаталсан эрүүл мэндийн тогтолцоо нь эрүүл мэндийн ерөнхий төлөв байдлыг, ялангуяа хөдөөгийн орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улс энэхүү санхүүжилт, үйлчилгээ хүргэх загвараас холдох хэд хэдэн алхам хийжээ. Жишээлбэл, эмчлэх үйлчилгээнд түлхүү төвлөрч байгааг больж, нийтийн эрүүл мэндэд анхаарах зорилгоор өрхийн эмнэлэг, сумын эмнэлгийг бүтцийн өөрчлөлтөд оруулж, өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн. Сумын эрүүл мэндийн төв нь төрийн өмчит байгууллагууд бол өрхийн эрүүл мэндийн төв нь хувийн байгууллагууд бөгөөд гэрээгээр төрийн өмнөөс эрүүл мэндийн үйлчилгээ хүргэдэг.

Алслагдсан сумуудад сумын эмнэлгийн (СЭМТ гэгдэх болсон) болон аймгийн лавлагаа түвшинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бол нэгдсэн эмнэлгүүд хөдөө орон нутагт анхан шатлалын болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн цогц үйлчилгээг үзүүлж байна. Хөдөөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь нөөц их шаарддаг; улмаар өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын нягтрал багатай оронд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг хангах нь нэн чухал юм.

1990-ээд оны эхээр засгийн газраас хэрэгжүүлсэн эхний хоёр шинэчлэл нь эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бий болгох замаар нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг дайчлах (Зөвлөлтийн нийгмийн тусалцаанаас гарч, улмаар санхүүгийн хямралыг арилгах зорилгоор), мөн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор үйлчилгээ үзүүлэхэд хувийн хэвшлийнхний оролцоог дэмжин тэргүүлэх чиглэлийг эрүүл мэндийн салбарт шилжүүлэх..

Олон улсын хөгжлийн байгууллагуудын, тэр дундаа Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Монгол улсын засгийн газар нийслэл, аймгийн төв болон бусад хотод эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг анхан шатны эмнэлгийн эмч нарын бүлгүүд болох өрхийн эмнэлгүүдийг (өрхийн эмнэлгүүд) байгуулсан.

2011 онд батлагдсан Эрүүл мэндийн тухай хуульд, түгээмэл, тэгш хүртээмжтэй, чанартай, үнэ төлбөргүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх заалтыг тусгажээ. Зайлшгүй авах үйлчилгээний багц улам өргөжин ирсэн ба нярай, хүүхэд, өсвөр насныхан, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, ахмад настны үйлчилгээ, халдварт ба халдварт бус өвчин, түргэн тусламж, сувилахуйн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг үйлчилгээг багтаасан болно.

Хот, суурин газруудад өрхийн эмнэлгүүд (өрхийн эрүүл мэндийн төв /ӨЭМТ/гэж нэрлэгдэх болсон) нь амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлж зөвлөгөө, өдрийн эмчилгээ, бусад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Хөдөөгийн сумдад байрлах сумын эрүүл мэндийн төвүүд нь (СЭМТ) нь газар зүйн хувьд алслагдмал бөгөөд өргөн уудам газар нутагтай тул хэвтэн эмчлүүлэх, үндсэн мэс засал, төрөхийн үйлчилгээ эрхэлдэг 10-15 ортой. Одоогийн байдлаар 549 анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, түүн дотор Улаанбаатар хотод болон бусад хотод 218 ӨЭМТ, хөдөө орон нутагт 331 СЭМТ ажиллаж байна. 2018 оны байдлаар, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд эрүүл мэндийн нийт зардлын 18.6 хувийг эзэлж, эрүүл мэндийн салбарын нийт ажилчдын 11.5 хувийг эзэлдэг эмч, сувилагч, бусад мэргэжлийн болон туслах ажилтнуудыг оролцуулан 5814 ажилтнуудыг анхан шатанд ажиллуулж байна. ӨЭМТ, СЭМТ нь нийт амбулаторийн үзлэгийн 48.9% -ийг үзүүлдэг бөгөөд СЭМТ-үүд хэвтэн эмчлүүлэгчдийн 15.4% -ийг эмчилдэг (Жигжидсүрэн нар, 2019).

СЭМТ нь алслагдсан бүсэд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд харьцангуй танигдсан байдаг бол ӨЭМТ-ийн хувьд тийм байдаггүй. ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээнд хүмүүс итгэдэггүй тул, ихэвчлэн ӨЭМТ-ийн алгасан дараагийн шатлалын улсын болон хувийн эмнэлгүүдэд илүү өргөн хүрээний үйлчилгээнд ханддаг байна.

Дотоод болон гадаад мэргэжилтнүүдийн үзэж буйгаар өрхийн эмнэлгүүдийг анх байгуулагдахдаа бүтцийн хувьд эхний загвараасаа гажуудаж, буруу явагдсан бөгөөд хэрвээ зохих ёсоор засахгүй бол бүхэлдээ нуран унах аюул тулгарч байна. Өөр өөр газруудаас явуулсан төрөл бүрийн төслүүдийн хүрээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар ӨЭМТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмж, түүнчлэн ажилтнуудын харилцаа, хандлагын тал дээр сэтгэл ханамж багатай байгааг дурдсан байна.

3.2 Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба сумын эрүүл мэндийн төв

Хэдийгээр өрхийн болон сумын эрүүл мэндийн төвүүд нэг иргэнээр тооцох аргачлалаар санхүүжиж анхан шатны үндсэн тусламж үйлчилгээг үзүүлж байгаа боловч ЭМЯ ихэнхи эрүүл мэндийн байгууллагуудыг төсвийн зардлын эдийн засгийн ангиллаар санхүүжүүлсээр байгаа. НДЕГ хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг 115 оношийн хамаарлын бүлэгтэй (ОХБ) тохиолдолд тулгуурласан төлбөрийн аргаар худалдан авч байна. Түүнчлэн эрүүл мэндийн байгууллагууд цөөн тооны үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.

Эрүүл мэндийн тухай хуулиар (2011) эрүүл мэндийн байгууллагуудыг чиг үүрэг, бүтэц болон үйл ажиллагааны хувьд өөрчлөн төлөвсөн. Жишээ нь, өрхийн болон сумын эмнэлгүүдийг ӨЭМТ болон СЭМТ болгон хуучин эмчилгээний үйлчилгээ гэхээсээ нийгмийн эрүүл мэндийн бодлого, стратегиудад анхаарал хандуулдаг болсон. ӨЭМТ-үүд нь дээр дурдсанчлан төрөөс санхүүждэг хувийн байгууллагууд ба нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг улстай байгуулсан гэрээгээр дамжуулан гүйцэтгэдэг боловч төсөв хомс, өрхийн эрүүл мэндийн эмч нарын ачаалал хэт их байгаагаас ялангуяа Улаанбаатар хотод хангалттай хөрөнгө, хүчин чадал хүрэлцээгүй байв. Түүнчлэн, том нутаг дэвсгэрт хүн амын нягтрал багатай тул эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээл тулгардаг.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ нь Монгол Улсын засаг захиргааны нэгжүүдээс зохион байгуулж буй нийгмийн түвшинд тулгамдсан асуудал бүхий эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний багц хэлбэрээр тодорхойлогддог. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд хот, хөдөө орон нутагт үзүүлэх байдал, үйлчилгээ үзүүлэгчдийн шинж чанар, чиг үүрэг, санхүүжилтийн механизмын хооронд ялгаа бий.

3.3 Төсөв ба санхүүжилт

Монголд анхан шатны тусламж үйлчилгээг төрөөс санхүүжүүлдэг ба ӨЭМТ болон СЭМТ-дэд ард иргэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдах боломжийг олгодог байна. Гэсэн хэдий ч алслагдсан байдал, эдийн засгийн хүндрэл, дотоодын шижилт хөдөлгөөн, ажилгүйдэл, эрүүл мэндийн үйлчилгээг хайх зан үйл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй хүмүүс байсаар байна.

Монгол улсын Засгийн газар нэг иргэнээр тооцох төлбөрийн механизмыг нэвтрүүлж, анхан шатны тусламж үзүүлэгч байгууллагуудтай гэрээ байгуулсан. Нэг иргэнээр тооцох

өртөг хэт бага болон насны ангилал, оршин суугаа газраар өөр байсан тул өртгийг нэмэх шаардалага гарсан. Засгийн газраас хийсэн тогтоолуудын дагуу нэг иргэнээр тооцох өртгийг 2012, 2015, 2017 онуудад үе шаттайгаар өсгөсөн.

Улсын төсвийг нэг хүнд ногдох өртөг, тохиолдолд суурилсан, төсвийн зардлын эдийн засгийн ангилалаар хуваарилдаг. Энэ нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бүх иргэдэд хүртээмжтэй болгож, санхүүгийн аюулгүй байдлыг хангаж, иргэн бүрт төвлөрсөн үйлчилгээг иргэн бүрт хүргэх үүрэг хүлээсэн Засгийн газрын үүрэг хариуцлагыг бэхжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын шинэчлэлээр дамжуулан анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах стратеги санаачилгыг нэвтрүүлэв. Энэхүү шинэчлэлийн үр дүнд өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, зарим сэргээн засах эмчилгээ, оношилгоо шинжилгээний үйлчилгээг хамруулах зорилгоор анхан шатны тусламж үйлчилгээний тэтгэмжийн багцыг өргөтгөсөн. Эдгээр үйлчилгээ нь тохиолдолд суурилсан төлбөрийн санхүүжилтээр хийгдэх бөгөөд одоогийн төлбөрийн системийг урт хугацааны зорилго, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээтэй холбох хөшүүрэг болох юм. Одоогоор хэрэгжиж байгаа бөгөөд 2018 онд анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 5.2 тэрбум төгрөг хуваарилагдсан бол 2019 онд 15.6 тэрбум төгрөгөөр төсөвт тусгагдсан байна.

3.4 Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ) нь эрүүл мэндийн даатгалын газрын үндсэн байгууллага бөгөөд тусламж үйлчилгээнд хамрагдсан өвчтөнүүдийн тоо, очиж үзсэн тоо эсвэл өвчтөнд үзүүлсэн үйлчилгээний төрлөөс хамааран үйлчилгээний төлбөрийг АШЭМТҮ үзүүлэгч байгууллагууд руу шилжүүлэн тусламж үйлчилгээнд хамруулдаг. Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 5-р сарын 08-ны өдрийн тогтоолоор батлагдсан эмчилгээний хуудас бүхий өвчтөний бүртгэл, цахим эрүүл мэндийн бүртгэлийн систем. эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний үр дүнг үнэлэх нотлох баримт бүрдүүлэх үндсэн хэрэгсэл.

2018 оноос өмнө АШЭМТҮ-ээг улсаас санхүүждэг байсау, эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт байгаагүй. Гэсэн хэдий ч нийгмийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийн ангиллын дагуу албан бус салбарын хүмүүс нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг бөгөөд малчин, ажилгүй, сайн дураараа төлдөг хүмүүс багтдаг.

Тиймээс, ялангуяа АШЭМТҮ-ний түвшинд давуу талыг олгохын тулд тэдгээрийг эрүүл мэндийн даатгалд хамруулах нь чухал юм. Нөгөө талаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зөвхөн магадлан итгэмжлэгдсэн АШЭМТҮ үзүүлэгч байгууллагууд гэрээ байгуулан нийгмийн даатгалын сангаас санхүүжих боломжтой болсон.

Мөн түүнчлэн, ЭМДЕГ 2015 оноос эхлэн даатгалд хамрагдасдад хөнгөлөлттэй үнээр эм олгох болсон. 2017 онд ДЭМБ-аас хийсэн судалгаагаар хүмүүс их хэмжээний зардал гаргадгийн шалтгаан нь үнэтэй, өртөг өндөртэй эм худалдаж авч байгаатай холбоотой байжээ.

2018 он гэхэд ЭМДЕГ эмийн хөнгөлөлтөд зориулж бараг 47,494.6 сая төгрөгийн санхүүжилт хийсэн бөгөөд энэхүү шинэчлэлээс манай улсын хүн амын бараг тал хувь нь үр шим хүртжээ. Сүүлийн таван жилийн хугацаанд төсөв бараг 4 дахин нэмэгдэж, тус сангаас ашиг хүртсэн хүмүүсийн тоо хоёр дахин нэмэгджээ. Энэ үе шатанд эрүүл

мэндийн даатгалд хамрагдалтын нийт хамрах хүрээ нь 2018 оны байдлаар 89% -д хүрсэн байна.

3.5 Хүснэгт 2 Нэг иргэнээр тооцох төлбөрийн томьёо

$$сар_{\text{ерх}} = \sum_{i=1}^n сар_{\text{бүлэг } i}$$

- $сар_{\text{ерх}}$ – өрхийн эрүүл мэндийн төвийн улсын төсвөөс санхүүжих нийт зардлын хэмжээ
- $сар_{\text{бүлэг}}$ - эрүүл мэндийн эрсдлийн бүлгээр ангилсан санхүүжилт
- n - эрүүл мэндийн эрсдлийн бүлгийн тоо
- i - эрүүл мэндийн эрсдлийн бүлгийн дугаар

№	Эмзэг бүлэг		Нэг иргэнд ноогдох төлбөр төгрөгөөр
	Насны бүлэг	Амьдрах газар	
1	0-5 нас	Гэр хороолол	26479.3
2		Байшин хороолол	23276.7
3	6-15 нас	Гэр хороолол	11266.9
4		Байшин хороолол	10466.3
5	16-49 нас	Гэр хороолол	12067.6
6		Байшин хороолол	12067.6
7	60 ба түүнээс дээш	Гэр хороолол	16871.5
8		Байшин хороолол	15270.1
9	Бусад	Гэр хороолол	9665.5
10		Байшин хороолол	8865.0

4. Сумын эрүүл мэндийн төвүүдийн /СЭМТ/ үр ашгийг үнэлэх арга зүй

4.1 Үр ашгийн түвшин болон тодорхойлогч хүчин зүйлүүдийг тооцоолох

Техникийн үр ашиг нь шийдвэр гаргах нэгжийн (цаашид ШГН гэх) хүчин чадлыг илэрхийлнэ. Манай судалгаа нь СЭМТ-ийн тодорхой хэмжээний орцыг үйлдвэрийн явцад оруулж ямар хэмжээний гарц гаргаж байгааг судлах юм. Гарц нь техникийн үр ашгийн хувьд тодорхой орцын түвшинд гарц хамгийн их байхаар, орц нь тодорхой үйлдвэрлэлийн түвшинд орцыг хамгийн бага байлгах чадваруудыг үнэлэх юм.

Энэхүү судалгаагаар орцыг 3 шалтгаанаар сонгосон болно.

Нэгдүгээрт, 5 аймгийн түүвэр судалгааны урьдчилсан тооцооллоор зарим эрэлтийн хүчин зүйлүүдийг сонгосон, тухайлбал сумын хамрах хүрээ, сумын хүн ам, нийгэм эдийн засгийн онцлог зэрэг нь СЭМТ-ийн үр ашигт нөлөөлсөн байна. Гэсэн хэдий ч СЭМТ нь эрэлтийн хүчин зүйл дээр харьцангуй бага хамрах хүрээтэй байдаг нь гарцын үр ашгийг нэмэгдүүлнэ.

Хоёрдугаарт, өмнөх хэсэгт үзүүлсэнчлэн, ойрын хугацаанд Монгол улсын эрүүл мэндийн зардал өсөх эсэх нь эргэлзээтэй хэвээр байна. Тиймээс Монголын эрүүл мэндийн тогтолцооны хангагдаагүй хэрэгцээ болон бусад бэрхшээлийг шийдвэрлэх боломжийг бий болгох зорилгоор СЭМТ-ийн нөөцийг хэр хэмнэх, чөлөөлөхийг үнэлэх нь хамгийн ач холбогдолтой юм.

Гуравдугаарт, зарим нэг орцуудыг СЭМТ-үүдийн түвшинд шууд тодорхойлох боломжгүй ч ЭМЯ, аймгийн эрүүл мэндийн төвийн түвшинд тодруулга хийж тодорхойлох боломжтой юм.

СЭМТ-ийн техникийн үр ашгийг тооцоолох боломжит 2 арга зүйд: параметрийн арга стохастик фронтиер шинжилгээг ашиглах (aignet et al., 1977), параметрийн бус арга DEA /мэдээллийн боловсруулалтын дүн шинжилгээний давхар ачааллах арга/ (Farrell, 1957; charnes et al., 1978), Free Disposal Hull /жишгийг өөртэй ойролцоо буюу үе тэнгийнхэнтэй нь харьцуулан судалдаг арга/ (deprins et al., 1984) зэргийг тооцоололдоо ашигласан юм. Параметрын арга нь үйлдвэрлэлийн функциональ хэлбэрийн талаархи нэмэлт төсөөллийг шаарддаг тул бид параметрийн бус аргыг ашигладаг. Цаашлаад параметрийн бус арга нь хэд хэдэн орц болон гарцыг оруулж үр ашгийн оноог тооцоолж болдог юм.

